

## Агуулга

1. Төслийн танилцуулга.....	3
2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга.....	9
2.1. Уур амьсгал .....	9
2.2. Хур тунадас .....	10
2.3. Салхи .....	10
2.4 . Геологийн тогтоц ба геоморфологи .....	11
2.5 . Гадаргын ус .....	12
2.6 . Хөрсөн бүрхэвч .....	12
2.7 . Ургамлын нөмрөг .....	12
3.Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	13
4.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	14
5.Нөхөн сэргээлт, орчны тохиожолтын төлөвлөгөө .....	18
6.Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
7.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....	21
8.Түүх соёлын өвийг хамгаалах, арга хэмжээний төлөвлөгөө .....	21
9.Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	22
10.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	25
11.Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний биелэлт.....	27
12.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт .....	28
1.Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт .....	30

### Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол.....	3
Хүснэгт 2. Ашиглалтын технологи .....	4
Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим .....	5
Хүснэгт 4. Хөрсний овоолгын төлөвлөлт.....	6
Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	14
Хүснэгт 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	18
Хүснэгт 7. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт.....	31

### Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн талбайн байршил.....	3
Зураг 2. Баяжуулах технологийн схем.....	8
Зураг 3. Дархан-Уул аймгийн агаарын дундаж температур /2021-2024 он/ .....	9
Зураг 4. Агаарын харьцангуй чийгшил 2021-2024 он.....	10
Зураг 5. Салхины хурд сарын дунджаар /2021-2024 он/ .....	10

## 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**Төсөл хэрэгжүүлэгч:** “Хотол даян” ХХК

**Төслийн нэр:** Хуурай чулуутын алтны шороон орд


**Регистрийн дугаар:** 4143817

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:**

**Төслийн байршил:** Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дахь Хуурай чулуутын алтны шороон ордын доод хэсэг нь Улаанбаатар хотоос 150 орчим км, Дархан-Уул аймгаас зүүн урагш 55 км, Шарын голын нүүрсний уурхайгаас 10 км зайд байрлана. MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь М-48-106 дээр байрлана.

**Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол**

Д/д	өргөрөг			Уртраг			Д/д	өргөрөг			уртраг		
	град	мин	сек	град	мин	сек		град	мин	сек	град	мин	сек
1	106	35	13.22	49	13	19.42	10	106	33	55.26	49	13	25
2	106	35	13.22	49	13	19.42	11	106	33	55.26	49	13	13.91
3	106	35	21.32	49	13	21.59	12	106	34	3.32	49	13	11.34
4	106	35	21.21	49	13	21.99	13	106	34	15.89	49	13	7.32
5	106	35	21.1	49	13	22.4	14	106	34	17.34	49	13	6.38
6	106	35	32.53	49	13	27.16	15	106	34	36.51	49	12	53.92
7	106	35	32.53	49	13	31.71	16	106	34	48.65	49	12	53.92
8	106	35	35.1	49	13	28.88	17	106	34	48.65	49	13	4.5
9	106	35	35.1	49	13	25	18	106	35	13.22	49	13	4.5



**Зураг 1. Төслийн талбайн байршил**

Хайгуулын ажлын үр дүнгээр ордын хэмжээнд бодитой В зэрэглэлийн 7-н блокод 60.98 мян.м3 элсэнд 316.68 мг/м3 дундаж агуулгатай шлихээр 19.31 кг, химийн цэврээр 16.92 кг алтны нөөц, боломжтой С зэрэглэлийн 4-н блокод 26.63 мян.м3 элсэнд 305.2 мг/м3 дундаж агуулгатай шлихээр 7.67 кг, химийн цэврээр 6.72 кг алтны нөөц, нийт бодитой болон боломжтой зэрэглэлээр 87.61 мян.м3 элсэнд 313.19 мг/м3 дундаж агуулгатай шлихээр 26.98 кг, химийн цэврээр 23.64 кг алтны нөөцийг тооцжээ.

## 2025 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

### Ил уурхайн ашиглалтын технологи, ажиллах горим

“Хуурай чулуут”-ын алтны шороон ордын доод хэсэг нь хөндий дагаж, зүүн хойшоо сунаж тогтсон, зөрөлт, зөрөлт-шилжилт хагарлаар зааглагдаж шаталсан байдалтай доош суусан, тууз хэлбэрийн блок үүсгэнэ. Алтны шороон орд суналын дагуу 520 м (доод)-545 м (дээд) хүрэх ба өргөн нь 45-100 м байна. Уг орд нь дээд, доод 2 давхаргаас бүрдэх бөгөөд дээд давхраас нь 6 блок, доод давхраас нь 5 блоктой. “Хуурай чулуут”-ын орд нь геологи структурын тогтцын хувьд нийлмэл, хүдрийн биеийн ашигт давхарга тууз хэлбэрийн энгийн тогтоцтой, алтны доод (доош суусан) ба дээд (дээш өргөгдсөн) давхарга, зөрөлт, ашигт давхарга харьцангуй зузаан зэргийг харгалзан үзэж III-р бүлгийн алтны шороон ордын шаардлагад нийцсэн гэж үзээд ордыг III-р бүлгийн ордод хамааруулсан байна. Хучаас хөрсний хамгийн зузаан нь хэсэг нь С-1 блокт 10.4 м, ашигт давхаргын хамгийн зузаан нь С- 2/1 блокт 2.13 метрээр тус тус тооцсон байна.

Ордын алт агуулсан элс, хөрсний зузаан, газарзүйн байрлал, хөрсний чулуулгийн шинж чанар зэргээс хамааруулан 2025 оны ашиглалтын жилд авто тээвэртэй, дотоод овоолготой ашиглалтын системийг хослуулж ашиглана.

**Хүснэгт 2. Ашиглалтын технологи**

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Тээвэртэй, дотоод овоолготой ашиглалтын технологи	1. Шимт хөрс хуулалт	1.1. Ухаж түрэх
	2. Хөрс хуулалт	2.1. Ухаж түрэх 2.2. Ухаж ачих 2.3. Тээвэрлэх 2.4. Овоолох
	3. Элс олборлолт	3.1. Ухаж ачих 3.2. Тээвэрлэх 3.3. Овоолох (агуулахад хураах)

### Ажиллах горим

Уурхай нь улирлын чанартай ажиллах бөгөөд баяр ёслолын болон амралтын үед ажилчдын амрах хугацааг МУ-ын “Хөдөлмөрийн тухай” хуулийн дагуу болон уурхайн даргын тушаалаар зохицуулна. Мөн бүс нутгийн цаг агаарын онцлог, уул тээврийн тоног төхөөрөмжүүдийн ажлын бэлэн байдал, тэдгээрийн техникийн нөхцөл боломжуудаас хамааран 2025 онд ажиллах хоногийн тоог тооцож хүснэгтээр үзүүлжээ. Уурхай нь улирлын чанартай ажиллах тул 2025 онд 7-р сарын 1-ээс эхлэн бэлтгэл ажлыг хангаж, 7-10-р сарыг дуустал хугацаанд

бэлтгэл ажил, амралт, баяр ёслол, засвар үйлчилгээний сул зогсолтоо тооцоод нийт 108 хоногийн хугацаанд ажиллахаар тооцоолов.

### Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Календарь цаг
2025 онд			
1	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10
2	Хоног дахь ээлжийн тоо	ээлж/хон	2
3	Жилд ажиллах хоногийн тоо	хоног/жил	108
4	Жилд ажиллах ээлжийн тоо	ээлж/жил	216
5	Жилийн календарь цаг	цаг/жил	2160

#### Ил уурхайн хүчин чадал, техник-технологи

Ил уурхайн хүчин чадал. 2025 оны 7-р сард уурхайн бэлтгэл ажлыг хангаж, уурхайд компанид байгаа техник, тоног төхөөрөмжүүдийг үргэлжлүүлэн ашиглах бөгөөд ордын үлдсэн нөөц болох 47.94 мян.м3 алттай элсийг олборлон баяжуулах хүчин чадалтайгаар ажиллана. Мөн тухайн онд хаалт нөхөн сэргээлтийн ажлыг хэрэгжүүлэх боломжгүй байна.

Ил уурхайн үндсэн техник, тоног төхөөрөмж. Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайг өөрт байгаа техник, тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан ашиглах бөгөөд тэдгээр тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан 2025 оны бүтээлийн тооцоог гүйцэтгэв.

Уурхайн уулын ажлын төлөвлөлтөөр 2025 онд 399.67 мян.м3 уулын цулыг уурхайгаас олборлоно. Одоогоор компанийн эзэмшилд VOLVO 460 маркийн 1 ш экскаватор, Hyundai R2900 маркийн 1 ш экскаватор, Weichai маркийн 70 тн даацтай 4 ш автосамосвал, Shantui SD-13 маркийн бульдозер 1 ш, ZI-50 маркийн утгуурт ачигч 1 ш зэрэг үндсэн техник тоног төхөөрөмжүүд бэлэн байна. Эдгээр тоног төхөөрөмж нь төлөвлөж буй ил уурхайн хүчин чадлыг бүрэн хангана. Хөрсний овоолго байгуулах, элсний овоолго түрэх, эфель гааль, шлам хураах бусад туслах ажилд, Shantui SD-13 бульдозер болон XCMG ZI-50 маркийн утгуурт ачигч ажиллана.

#### 2025 оны уулын ажлын төлөвлөгөө

Уурхайн бэлтгэл ажил 2025 оны 07-р сарын 1-ээс эхлэх бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, зарим шаардлагатай засвар үйлчилгээний ажлууд хийгдэнэ.

Ашиглалтын хоёр дахь жил буюу 2025 онд ордын Дээд, доод давхаргын С-1, В-1, В-2, В-3, В-4, С-2, С-1/1 гэсэн блокууд дээр ажиллахаар төлөвлөв. Дээрх блокуудаас нийтдээ 2025 онд

351.73 мян.м3 /сийрэгжилт тооцсоноор 404.5 мян.м3/ хөрсийг дотоод овоолгод хураана. Мөн баяжуулах төхөөрөмж энэ оны 7 сараас ажиллаж эхлэх бөгөөд тухайн жилд 47.94 мян.м3 элс угааж баяжуулна.

#### Олборлолтын процесс

Ил уурхайн үндсэн үйл ажиллагаа нь уурхайн хөрс хуулалт, олборлолт, овоолго байгуулах болон туслах ажлуудыг иж бүрнээр нь аюул осолгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах, зорилгод бүтээлийг хангах ёстой.

Уурхайд дараах процессууд явагдана:

Өнгөн хөрсийг түрэх

Хөрс болон алт агуулсан элсийг түрэх, ухаж ачих, тээвэрлэх

Овоолго үүсгэх

Хөрс хуулалтын ажилд VOLVO 460 маркийн экскаватор, элс олборлолтын ажлыг Hyundai R2900 маркийн экскаватор болон 70 тн даацтай Weichai автосмосвалын хослолоор гүйцэтгэнэ.

Автосамосвалын тооцоо. Уурхайд хөрс болон элс тээвэрлэлтийн ажил нь авто тээврээр хийгдэнэ. Уурхайгаас гарах хөрсийг тээврийн зай хамгийн бага, техникийн нөхөн сэргээлт хийхэд хялбар байх зэрэг нөхцөлүүдийн үндэслэн дотоод овоолгод хураана. 2025 онд хөрс

тээврийн зай 0.6 км, элс тээврийн зай 0.8 км байна. Тээврийн ажилд автосамосвалын ачаатай /элс/ явах дундаж хурд 20 км/цаг, хоосон явах дундаж хурд 30 км/цаг ба хөрс тээвэрлэх үед ачаатай явах хурд 18 км/цаг, хоосон үед 25 км/цаг байна.

уурхайн хөрсний тээвэрлэлтэд БНХАУ-ын 70 тн даацтай автосамосвал 2 ш, элс тээвэрлэлтэнд 1 ш автосамосвал байхад хангалттай харагдаж байна.

Бульдозерын тооцоо. Тус уурхайн хэмжээнд шимт хөрсийг хуулах, дотоод овоолго байгуулах, ажлын талбайг засах, нөхөн сэргээлтийн ажил хийх, ашигт малтмалын давхаргын ул, таазны цэвэрлэгээ хийх зэрэгт бульдозер ашиглах бөгөөд эдгээр ажилд SD-13 маркийн бульдозер ажиллуулахаар тооцлоо.

Хөрсний овоолго. Хөрсний гадаад овоолгыг уурхай хажууд буцааж дүүргэхэд хялбар байх техникийн шийдлийг харгалзан байршуулна. 2025 оны ашиглалтын жилд уурхайн дээд доод давхаргаас гарсан 351.7 мян.м3 /сийрэгжээгүй/ хөрсийг дотоод овоолгод хураахаар төлөвлөв.

#### Хүснэгт 4. Хөрсний овоолгын төлөвлөлт

№	Ашиглалтын жил	Хэмжих нэгж	Хуулах хөрс	Сийрэгжилт тооцсон
1	2025 нд	мян.м3	351.73	404.5

Элсний түр овоолго. Энэ жилд дунджаар 47.9 мян.м3 элс олборлоно. Уурхайгаас олборлох элсийг уурхайн хажууд байрлах баяжуулах үйлдвэрийн дэргэд түр агуулахад хураан ZI-50 маркийн утгуурт ачигчаар баяжуулах төхөөрөмжийг тэжээнэ.

#### Замын ашиглалт, үйлчилгээний процесс

Зам засвар, ашиглалт, үйлчилгээний ажилд зам тэгшлэх, замын бартаа саадыг арилгах, замын эвдрэлийг засах, халтиргаа гулгаа үүсэхээс хамгаалж зам дээр элс, давс цацах, цас мөс арилгах, замыг цас бороо болон шар усны үерээс хамгаалах, зам усалгаа тоос дарах зэрэг ажлууд орно.

Уурхайн бусад тээвэр. Ил уурхайн замыг байнга хянах ба засаж тэгшлэх, цэвэрлэх, тоос дарах ажиллагааг гүйцэтгэнэ. Эдгээр ажилд компанид байгаа усалгааны машин, XCMG ZI-50 утгуурт ачигч зэрэг тоног төхөөрөмжийг ашиглана. Ил уурхайн тоног төхөөрөмжүүд нь ээлжид 0.5-1 тн түлш хэрэглэнэ. Тоног төхөөрөмжүүдийг түлшээр хангах 3 тн даацтай түлш цэнэглэгч автомашин ажиллана. Уурхайд ажиллах инженер техникийн ажилчдын ашиглах жийп машин 2 ширхэг байна.

#### БАЯЖУУЛАЛТЫН ТЕХНОЛОГИ

“Хуурай чулуут”-ын алтны шороон ордын алт агуулсан элснээс 2021 онд 260 кг сорьцонд “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын лабораторид технологийн туршилт шинжилгээ гүйцэтгэсэн байна.

Туршилт шинжилгээний ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд: Эрдсийн найрлагын нарийвчилсан судалгаа, Гравитацын баяжигдах чанарын туршилт шинжилгээ, дүгнэлт; тухайн орд газрын хэсгээс авсан технологийн сорьц

дээжийг гравитацийн аргаар баяжуулах технологийн схемийг боловсруулан алт агуулсан баяжмал ялгах туршилт шинжилгээг явуулсан байна


### **Баяжуулах хэсгийн технологи схем, бүтээгдэхүүн гаргалт**

Шороон ордын алт баяжуулах үндсэн технологи нь уг ордын эрдсийн бүрэлдэхүүний онцлог, угаагдах шинж чанарт тохирсон технологийн горимыг сонгож авдаг. Тухайн ордын онцлогт тохирсон технологи нь алт агуулагч чулуулгийн найрлага, бүтэц, угаагдах шинж чанар, материалын ширхэглэлийн хэмжээ, тоосонцор алтны эзлэх хувь, агуулга, хэлбэр хэмжээ, шигшүүрийн нүхний диаметр, металл хуримтлал, технологийн ус, хатуу шингэний харьцаа, насосын даралт, усны эрчим зэрэг хүчин зүйлээс ихээхэн хамаардаг.

Элс угаан задлалт: “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын алт агуулагч элс нь угаагдах шинж чанарын хувьд хялбар угаагдах ангилалд багтаж байгаа учир угаан задлах ажиллагааг скруббер ашиглан гүйцэтгэнэ. Ингэснээр алт агуулагч элсийг сайтар угаан задалж баяжуулалтад оруулахад бэлэн болгоно. Скруббер нь +20мм-ийн ангиллыг галийн овоолгод хураана. Харин -20мм –ийн ангиллын элсийг шлюзэд тэжээнэ.

Элс угаан баяжуулалт: -20мм-ийн ширхэглэлтэй элсийг нам дүүргэлтийн гидро шлюзээр баяжуулна. Энд том ширхэгтэй алт суух бөгөөд нам дүүргэлтийн шлюзийн баяжмал нь харьцангуй их хэмжээний элстэй байх учир алт агуулсан баяжмалыг зориулалтын саванд хийж гүйцээн баяжуулах цехэд авчирч баяжуулна. Хаягдал нь хаягдлын санд урсан орж тунана. Гүйцээн баяжуулахад ирсэн баяжмалыг шигшин, -2.0 мм ангиллын бүтээгдэхүүнийг сэгсрэх ширээгээр баяжуулах ба +2.0 мм ангиллын бүтээгдэхүүн болон ширээний баяжмалыг гар тэвшээр баяжуулан соронзон ялгагчаар ялгаж хатаагаад гар аргаар үлээнэ.

Хаягдлын сан: Скрубберээс гарсан +20мм-ийн ангиллыг галийн овоолгод хураах бөгөөд нам дүүргэлтийн шлюзийн хаягдлыг хаягдлын санд хураана. Хаягдлын санд тунаж цэвэршсэн ус эргэлтийн усан санд өөрийн урсгалаар урсан орно. Эргэлтийн усан санд хуримтлагдсан усыг технологийн процесст эргүүлэн ашиглана.



Зураг 2. Баяжуулах технологийн схем

**Хаягдлын далан.** Ордын 2025 оны ашиглалтын жилд баяжуулах цехээс 47.87 мян.м<sup>3</sup> эфел, гаалийн хаягдал гарах ба үүнийг уурхайн ашиглагдсан орон зайд нөхөн дүүргэлт хийж нөхөн сэргээх боломжтой байна. Хаягдлын агуулга 21.5 мг/м<sup>3</sup>. Хуурайн чулуутын алтны шороон ордын элсийг усаар задлахад гарах шламын тунах хурд хурдан, шаврын агууламж нь харьцангуй бага тул одоо ашиглаж байгаа нэг нууртай хаягдлын технологийг үргэлжлүүлэн ашиглана. Хаягдлын сангийн багтаамж нь ойролцоогоор 8600 м<sup>3</sup> байна. Цэвэр усны сангийн хэмжээ 5900 м<sup>3</sup> байна. Баяжуулах үйлдвэрт зарцуулах нэмэлт цэвэр усны хэрэглээг Шарын голоос татан хангахаар төлөвлөв.

**Ундны усан хангамж.** Уурхай нь улирлын чанартай ажиллах ба уурхайн хотхонд байнга 32 хүн ажиллаж амьдарна. Оршин суугч нэг хүний хоногийн усны хэрэглээг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтаар нэг ажилчны ээлжид буюу ажлын байранд хэрэглэх халуун болон хүйтэн усны хэрэглээ 20-200л/хон байна. Хоногт зарцуулагдах хэрэглээний усны 1 хүнд оногдох хэмжээ дунджаар 25 л гэж үзвэл, нийт хэмжээ 800 л буюу 0.8 м<sup>3</sup>/хон (0.01 л/сек) болно. Унд ахуйн усны хэрэгцээг тусгай зөвшөөрлийн талбайн баруун талд залгаа талбайд байх худгаас хангана. Гүний худгийн усны ундарга нь 3.7 л/сек бөгөөд ахуйн усны хэрэгцээг бүрэн хангах боломжтой байна.

## 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1. Уур амьсгал

Дархан-Уул аймгийн цаг уурын онцлогийг авч үзвэл эх газрын эрс тэс уур амьсгал зонхилох ба энэ нь хоногийн болон улирлын агаарын температурын хэлбэлзэл ихтэй, жилийн хур тунадасны хувиарлалт харилцан адилгүй, агаарын хуурайшилт ихтэй, урт хүйтэн өвөл болдог зэргээр тайлбарлагдана. Олон жилийн дундажаар жилийн агаарын дундаж температур 1-р сард  $-24.1$  хэм, 7-р сард  $+20.4$  хэм хүрдэг. Жилийн дундаж хэм  $-0.6$ . Өвөлдөө  $-25-30$  хэм хүйтэрч, зундаа  $+30-35$  хэм хүртэл халдаг. Хур тунадас ихтэй, жилийн хур тунадасны нийлбэр олон жилийн дундажаар  $302.0$  мм хүрэх ба түүний ихэнх нь  $/288.1\text{мм}/$  IY-X саруудад хур борооны хэлбэрээр унадаг. Судалгаа явуулсан жилд агаарын температур олон жилийн дунджын орчим, харин хур тунадас олон жилийн дунджаас арай ахиу байлаа. Дархан сум нь Хангай, ойт хээрийн бүст Хараа, Ерөө голын сав газарт далайн төвшнөөс дээш  $700-1000$  метрт өргөгдсөн, цаг уурын эрс тэс уур амьсгалтай, өвөл зуны улиралд нэмэх хасах  $38$  хэм хүрдэг. Жилд дундажаар  $256$  мм хур тунадас унадаг.

#### Агаарын температур

Дархан-Уул аймгийн агаарын жилийн дундаж температур 2021-2024 оны хугацаанд  $0.35$  хэм, 1-р сарын дундаж  $-21$  хэм, 7-р сарын дундаж  $16.06$  хэм орчим байжээ. Тус нутагт дулааны улирал 5-р сараас 10-р сарын эх хүртэл, хүйтний улирал 11 сараас 4 сар хүртэл үргэлжилнэ.

Доорх жилүүдэд хамгийн хүйтэн өдөр 2023 оны 1 сарын 23-нд  $-42.1$  хэмтэй байсан бол хамгийн халуун өдөр 2023 оны 07 сарын 30-нд  $+34.5$  градустай байжээ.

Их хүйтэн өдөр  $20-30$ , их халуун өдөр  $10-20$  байх магадлалтай. Хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа  $90-110$  өдөр. Хаврын цочир хүйтрэл 5-р сарын 27-ноос 6-р сарын 1, хамгийн эрт 5-р сарын 18, хамгийн хожуу нь 6-р сарын 5-нд тохиолдоно. Намрын анхны дундаж хүйтрэлт 9-р сарын 4, намрын анхны хамгийн эрт хүйтрэлт 9-р сарын 2-нд, хожуу нь 9-р сарын 29-нд болно.




Зураг 3. Дархан-Уул аймгийн агаарын дундаж температур /2021-2024 он/

Судалгааны жилүүдээс сарын дунджаар 2024 оны 7-р сарын дундаж температур 21.1 хамгийн өндөр температуртай, 2021 оны 1-р сард дундаж температур -22.35 хэмтэй хамгийн хүйтэн сар байжээ.

## 2.2. Хур тунадас


Жилийн дундаж агаарын харьцангуй чийг 66.47% байна. Өвлийн улиралд агаарын харьцангуй чийг хамгийн их утгадаа хүрч 60-74.9%, зуны улиралд 2 дахь их утга нь ажиглагдаж 61-80.8%, хавар, намрын улиралд бага утга нь ажиглагдаж 44-56% хүрч буурдаг байна.



Зураг 4. Агаарын харьцангуй чийгшил 2021-2024 он

## 2.3. Салхи

Салхи ихэвчлэн баруун хойд чиглэлтэй бөгөөд жилийн дундаж хурд 3.5-4.0 м/с, саруудын хамгийн их хурд 5, 4-р сард оногдох бөгөөд 5.3 м/с-ээс дээш байна.



Зураг 5. Салхины хурд сарын дунджаар /2021-2024 он/

Дархан-Уул аймгийн хувьд салхины хурд хамгийн өндөр үе 4-р сар бөгөөд судалгааны жилүүдийн дундаж хурд 3.2м/с, салхины хурд 1-р сард хамгийн бага буюу дундаж хурд нь 0.9м/с байжээ.

Сүүлийн 5 жилд салхины хурд хамгийн өндөр үе нь 2021 оны 4 сард 3.6м/с хүрч байжээ. Жилийн 12,1,2-р саруудад салхины хурд бага байдаг бөгөөд тухайн жилүүдээс 2021 оны 1,12-р саруудад 0.9м/с байж хамгийн бага байжээ.

#### 2.4. Геологийн тогтоц ба геоморфологи

“Хотол даян” ХХК-ийн алтны шороон ордыг ашиглах төслийн талбай оршиж буй дүүрэгт дунд кембри-доод ордовикийн насны Хараагийн серийн тунамал- хувирмал чулуулаг болон дээд дөрөвдөгч-орчин үеийн насны аллювийн, делюви-пролювийн гаралтай сэвсгэр хурдас чулуулгууд тархсан байх бөгөөд эдгээр хурдас чулуулгийн талаархи судалгааг олон эрдэмтэн судлаачид болох А.А.Кулеш 1962, Ж.Жамбаа, А.Ботезату 1970, П.Баатар, Г.И.Хубальдигов 1972, В.М.Якимов 1971 зэрэг 1:200000-ын болон А.Кампе 1968, Б.Пүрэвсүрэн, Н.Н.Кузнецов 1986-1990, Б.Батром, С.Төмөр 1989-1991 зэрэг 1:50 000-ын масштабын геологийн зураглалын ажлуудаар нарийвчлан судалсан байна.

#### Гүний чулуулаг

Талбайд тархсан гүний чулуулгийн геологи-структурын байршил, давхарга зүйн хурдастай болон өөр хоорондоо харьцсан хил заагийн харьцаа петрограф, петрохимийн онцлог шинжүүдэд тулгуурлан дараах бүрдлүүдийг ялгасан байна. Үүнд:

-Дунд хожуу ордовикийн Бороо гол бүрдэл

-Түрүү девоны интрузив бүрдэл

Эдгээр гүний бүрдлүүдээс гадна бага гүний доод девоны зуунмод субвулкан бүрдлийг ялган зурагласан онцлогтой гэж үзжээ.

Дунд хожуу ордовикийн бороо гол бүрдэл (v-δ-γδO<sub>2-3b</sub>) Хараа голын зүүн хажуу болон талбайгаас баруун, баруун хойш тархсан уг бүрдлийн чулуулгийг Д.Бямбаа, Л.Баатар, Д.Гомбодорж нарын хийсэн геологийн 1:200 000-ны харьцлын зураглалын ажлаар 1951 онд А.Г.Тимофеевийн анх ялгаж, 1958 онд Ю.М.Арсеньев нарын ялгасан доод палеозойн габбро-гранодиорит-гранитын комплексийн Хазарын интрузив дэд комплекст хамааруулсан байна. Зураглалын ажлаар уг комплексийг 4-н фазад ялгаж үзсэн байдаг УГЗ-200 төслийн ажлаар энэ комплексийг хэд хэдэн бүрдэлд ялгаж зурагласан байна.

Уг бүрдэл нь кембри-ордовикийн Хараа группын хурдас, дунд ордовикийн хүрэн-өндөр формаацийн хурдсуудыг зүссэн харьцаа үүсгэх бөгөөд агуулагчаа роговикжуулсан, зарим хэсэгтээ эпидотжсон, хлоритжсон хэдэн арван метр өргөнтэй заагийн хувирлын бүс үүсгэх ба хожуу насны гүний бүрдлүүдээрээ зүсэгдсэн байдаг. үүсгэж байгаа массив, биетүүд нь өнөөгийн байдлаар голчлон зөв биш хэлбэртэй байх бөгөөд зарим хэсэгтээ тектоник хагарлын дагуу сунасан байдалтай ажиглагдаж байна.

**Тектони:** Төслийн талбай байрлах район нь Хойд Монголын атриат системийн Тариат-Сэлэнгийн структур-формацийн бүс, Монгол-Өвөр Байгалийн атриат

системийн Хойд Хэнтийн структур-формацийн бүсийн заагийг дамнан өнгөрсөн зүүн хойш чиглэлтэй Баянголын гүний хагарлын бүсээр хаяа нийлсэн байна. Районы нутаг дэвсгэрийн дийлэнх хэсэг нь Хойд Хэнтийн захын өргөгдлийн бүсэд ордог. Агуулахын талбай районы хэмжээнд тектоник структурын хөгжлийн түрүү каледоны /байгалийн/, каледоны, герцинийн, мезозойн тектоник магмын идэвхжилийн ба кайнозойн неотектоникийн гэсэн таван үе шат тусгалаа олсон гэж үзэж нөөцийн тайланд дэлэгрэнгүй дурьдсан байдаг.

## 2.5. Гадаргын ус

**Ус зүйн муж:** Хойт мөсөн далайн ай сав

**Сав газар:** Хараа-Ерөө гоолын сав газарт багтана. Гадаргын усны сүлжээ сайн хөгжсөн, байнгын урсгалтай гол, горхи олон учир ус зүйн хувьд сайн судлагдсан.

Хараа гол: Хэнтий нурууны баруун урд хажуугийн салбар уулсаас эх авах Баянгол нь Хараа голын эх юм. Хараа голын ус хурах талбай 14538 ам км, 310 км урт, дундаж уналт нэг километр 4 метр ба голын өргөн нь дээд хэсэгт (Мандал гол) 15-20 метр, дунд хэсэгтээ (Түхэл өртөөний хэсэгт) 20-30 м, адагтаа (Дархан хот) 30-45м өргөн байна.

## 2.6. Хөрсөн бүрхэвч

Энэ нутаг нь хөрс-газарзүйн мужлалаар Тал газар, хөндий хотгорын хөрс дэд бүсэд багтана. Гадаргын үнэмлэхүй өндөр 900-1000 м хүрнэ. Тус талбайд ердийн хар хүрэн ба нугат хүрэн хөрс зонхилно.

Дархан-Уул аймаг, Хонгор сумын нутагт хэрэгжих “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийн эзэмшил газар нь тэгшивтэр талд голын хөндий дагаж байрлана. Судалгааны талбайн хөрс нь Монгол орны хөрсний ангиллын дагуу уулын хээрийн хөрсний ангилалд багтах бөгөөд **Ердийн хар хүрэн ба нугын хар хүрэн, элсэнцэр механик** бүрэлдэхүүнтэй байна.

## 2.7. Ургамлын нөмрөг

Монгол орны нийт нутаг дэвсгэрийг ургамалжилтын 6 бүс, бүслүүрт ерөнхийлөн хуваадаг ба судалгааны талбай нь **Ойт хээрийн бүсэд** байрлаж байна. Харин ургамал газарзүйн тойргийн ангиллаар **Монгол дагуурын тойрогт** хамаарна.

Тусгай зөвшөөрлийн талбайд ургамлын ангиллаар уулын ойт хээр, ургамлын бүлгээр Уулын хээрийн нугын, **Хялгана-хиаг-алаг өвст бүлгэмдэл** зонхилно.

### 3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (цаашид БОМТ гэх) байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр заасан..

“Хотол даян” ХХК-ийн “Хуурай чулуултын ажлтны шороон орд” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төлөвлөсөн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон БОМТ боловсруулсны дагуу гүйцэтгэсэн.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 31.4 дэх заалт болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.6, 9.7 дахь заалт, 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах, батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгов. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлс хийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг хангаж, явцад нь хяналт тавин ажиллах болно.

Уг төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчны тухай хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартуудын дагуу төслийн үйл ажиллагааны улмаас үүсэж болзошгүй болон голлох сөрөг нөлөөллийг бууруулахын тулд авах арга хэмжээ, түүнд шаардагдах зардлыг тусгалаа. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах боломж бүрдэхээс гадна төслийн хэрэгжих чадварыг дээшлүүлж, эдийн засгийн үр ашиг нэмэгдэнэ.

#### 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Биелэлт	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	9
1	Агаарын чанар Салхины хурд 10 м/с үед тээвэрлэлтийн замаас үүсэх тоосонцрын агууламж стандарт хэмжээнээс давж болзошгүй	Уурхайн дотоод замыг услах	Тоос босох гадаргуу	Мот/цаг	800 000	Замын усалгааг шаардлагатай үед хийж ажилласан	<ul style="list-style-type: none"> <li>- Агаарын тухай хууль</li> <li>- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль</li> <li>- MNS 4585:2016</li> <li>- MNS 3384:82</li> </ul>
Уурхайд ажиллаж байгаа машин техникийн кабин доторх агааржуулах төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч бүхээгт тоос орохгүй болгох арга хэмжээ авч байх		Уурхайн бүх авто машинуудад	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Ажил эхлэхээс өмнө тогтмол техник хэрэгслүүдийг үзлэг оношилгоонд оруулж ажилласан.		
Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.		Уурхайн хэмжээнд	-	Хяналт шинжилгээний ажлын зардалд орсон	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлж салхины хурд багатай үед олборлолт явуулсан.		
Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.		Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Уурхайд ашиглаж байгаа техник хэрэгслүүдийн агаарын бохирдлын төлбөр төлж ажилласан.		
	<b>Нийт</b>				<b>800000</b>		

2	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Сав газартай ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөрөө төлнө			Дотоод үйл ажиллагааны зардалд	Хараа-Ерөө голын сав газартай ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулж, ус ашигласан төлбөр төлсөн.	Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015 MNS 5850:2008
		Ажилчдын хотхоны гадна 2 00-ын шинэчлэл, доторлох ажил	Үүний зардал 1000000			Жорлонгийн шинэчлэлийн ажил хийсэн	
		Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Зардал нь хяналт шинжилгээний зардалд орсон			-	
<b>Нийт</b>		<b>1000000</b>					
3	Газрын хэвлий болон Хөрсөн бүрхэвч	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Уурхайн хэмжээнд	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Газар ашигласны төлбөрийг төлсөн	MNS 5916:2008 MNS 5917:2008
		Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулна.	Засварын талбай,	-	500000	Засварыг хатуу хучилттай газар хийсэн	MNS 5918:2008
<b>Нийт</b>		<b>500000</b>					
4	Ургамлан нөмрөг болон Амьтны аймаг	Ургамлын зүйлийн бүрдлийн судалгаа	Уурхайн зам, уурхайн хил хязгаар	-	Орчны хяналт шинжилгээний зардалд	-	Амьтны тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
		Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байрлуулна.	Уурхайн хотхонд	-	500000	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардлаар гүйцэтгэсэн	
<b>Нийт</b>		<b>500000</b>					
5	<b>Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал</b>		<b>2800000</b>				


Ус ашиглах гэрээ, зөвшөөрөл



"ХОТОЛ ДАЯН" ХХК-д



Зөвшөөрөл олгох тухай



2025 оны 06 сарын 03 –ны өдөр Дугаар № 16 Дархан-Уул аймаг

Ус ашиглах гэрээ, зөвшөөрөл хүргүүлэх тухай

Монгол Улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт мөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2025 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн Е-2505-000110 дугаар ус ашиглуулах дүгнэлт, танай компанийн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 01/120 тоот хүсэлтийг тус тус үндэслэн "Хотол даян" ХХК-д ус ашиглуулах гэрээ байгуулан, зөвшөөрлийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 5...хуудастай.



2025 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 88

Дархан

Монгол улсын "Усны тухай хууль"-ийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2025 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн Е-2505-000110 тоот ус ашиглуулах дүгнэлт, "Хотол даян" ХХК-ийн 2025 оны 05 сарын 29-ний өдрийн 01/120 тоот ус ашиглуулах гэрээ байгуулж зөвшөөрөл гарлуулах тухай албан хүсэлтийг үндэслэн ТУШААХ нь:

